



БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



германы
хэлтийн дэмжлэг
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ
ХАМГААЛАХ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД
ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ**

17042 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,

Б.Шаравын гудамж-6, Хан-Уул тауэр, 1201 тоот

Утас: +976-70140166, 70140188,

Э-шуудан: piubaccp@gmail.com,

<http://www.baccp.mn>

2025. 05. 20 № 25/24

танай _____-ны № _____-т

Хяналт-шинжилгээ үнэлгээний

2024 оны тайлан хүргүүлэх тухай

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II, III” төслийн 2024 оны “Хяналт-шинжилгээ үнэлгээний” жилийн эцсийн тайланг Засгийн газрын 2016 оны 173 дугаар тогтоолын дагуу, Сангийн Сайдын 193 дугаар тушаалаар баталсан “Төслийн хяналт-шинжилгээний тайлан”-гийн загвар маягт-15 дагуу боловсруулан, хүргүүлж байна.

Хавсралт ³⁶... хуудастай

Хувийг: Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газар,

Хяналт үнэлгээ, аудитын газарт

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



Н.БАТДОРЖ

002553



БАЙГАЛЬ ОРЧИН,
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ



KFW



ГЕРМАНЫ САНХҮҮГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

**БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ХАМГААЛАХ,
УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ТӨСӨЛ**
BMZ 2012 65 511-I үе шат,
BMZ 2016 67 054-II үе шат,
BMZ 2018 68 272-III үе шат

Төслийн 2024 оны хяналт- шинжилгээний тайлан

Төсөл хэрэгжүүлэх нэгж

2025 оны 01 дүгээр сарын 19

ГАРЧИГ

1. ХУРААНГҮЙ	16
2. ТӨСӨЛД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ.....	27
3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ	18
3.1. Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал	18
3.2. Төсөл, арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө	19
3.3. Төсөл, арга хэмжээний зорилтын биелэлт, үр дүнтэй байдал	17
3.4. Үр дагаварт хүрч буй байдал, үйл ажиллагаануудын хэрэгжилт.....	
3.5. Үнэлгээний зорилго, хэрэглэсэн арга зүй, сул тал	20
4. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ	
5. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ.....	1
5.1. Стратегийн зорилготой нийцтэй байдал	2
5.2. Бодлогын орчин	4
5.3. Эдийн засаг, санхүүгийн үндэслэл.....	5
5.4. Байгууллагын хүчин чадал.....	6
5.5. Нийгэм-соёлын асуудал	7
5.6. Оролцоо ба өмчлөл	7
5.7. Жендер	8
5.8. Байгаль орчин	8
5.9. Тохиромжит технологи	8
6. ХЭРЭГЖИЛТИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ	8
7. ДҮГНЭЛТ БА ЗӨВЛӨМЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ САНАЛУУД	9

Товчилсон үгсийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНХАЖЯ	Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БОЯБ	Биологийн олон янз байдал
БОЯБХУАӨДЗ	Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
БЦГ	Байгалийн цогцолборт газар
ГСБЗБ/ KfW	Германы сэргээн босголт зээлийн банк
ДЦГ	Дархан цаазат газар
ЗБ	Зөвлөх баг
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУ	Монгол Улс
МУИС	Монгол Улсын Их Сургууль
МТ	Менежментийн төлөвлөгөө
МУАБУ	Менежментийн үр ашигт байдлын үнэлгээ
ОБ	Орчны бүс
ОБЗЭС	Орчны бүсийн зээлийн эргэлтийн сан
УХ	Удирдах хороо
ТББ	Тендерийн бичиг баримт
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ТХГН	Тусгай хамгаалалттай газар нутаг
ТХГНБХГ	Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газар
ТХБНУГ	Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газар
ТХГНУГ	Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын газар
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УТХГ	Улсын тусгай хамгаалалттай газар
УХ	Удирдах хороо
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХЗ	Хамгаалалтын захиргаа
СЯ	Сангийн яам
СХОХ	Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ

Эх сурвалжууд:

<https://nature.ov.gov.mn/d/sanal/208>

<https://www.giz.de/de/downloads/giz2024-mo-spaces-ii.pdf>,

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=16532581193551>

https://www.facebook.com/story.php/?story_fbid=861799006087870&id=100067733361317

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1: Төслийн арга хэмжээний биелэлт (зорилт тус бүрээр)

Хүснэгт 2: Төсөл арга хэмжээний үр дүнтэй байдал

Хүснэгт 3: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн ХШҮ-ний ажлын хэрэгжилт (жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 3: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн ХШҮ-ний ажлын хэрэгжилт (жилийн эцсийн байдлаар)

Хүснэгт 4: Төслийн гэрээний хэрэгжилт

Хүснэгт 5: Төсөл уялдан хэрэгжих бодлогын бичиг баримтууд

Хүснэгт 6: Төслийг тайлагнах

Хүснэгт 7: Төслийн хэрэгжилтийн ХШҮ, төслийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарах асуудал, санал зөвлөмж

Зургийн жагсаалт

Зураг 1: Төсөл арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө

Зураг 2: Төслийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх ажлуудын захиалагч талын санал

Зураг 3: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт (жилийн эцсийн байдлаар)

Зураг 4: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн үйл ажиллагааны төрөл, хэрэгжилтийн төлөв (жилийн эцсийн байдлаар)

Зураг 5: 2024 оны хэрэгжээгүй үйл ажиллагаанууд (жилийн эцсийн байдлаар)

Зураг 6: Төслийн II, III шатны Худалдан авах ажиллагааны биелэлтийн нэгтгэл (он оноор)

Зураг 7: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт (жилийн эцсийн байдлаар)

Зураг 8 Үнэлгээний матриц, аргачлал

Зураг 9: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны шинэчлэгдсэн бүтэц

Зураг 10 Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлого

Зураг 11 Төслийн санхүүжилтийн хуваарь, 2024 оны санхүүгийн гүйцэтгэл

Зураг 12: Төслийн бүтэц орон тооны шийдвэр, сул олон илүү орон тооны мэдээлэл

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Сангийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 193 дугаар тушаалын хавсралт маягт 15

Хавсралт 2. Төслийн II шатны Засгийн газар хоорондын хэлэлцээр, санхүүжилтийн гэрээ болон Тусгай гэрээ

Хавсралт 3. Төслийн 2023 оны худалдан авах ажиллагааны болон үйл ажиллагааны тайлан

Хавсралт 4. ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны тайлан, албан бус орчуулга

Хавсралт 5. ТХН-ийн удирдлагын мэдээлэл

Хавсралт 6. Төслийн II шатны Бүтэц орон тооны Тусгай гэрээний заалт, шийдвэр

Хавсралт 7. KFW банкны 2024 оны 10 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд хийсэн мониторингийн үнэлгээний хурлын тэмдэглэл

Хавсралт 8. KFW банкны явцын үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Хавсралт 9. Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, үйл ажиллагааны 2024 оны тайлан

Хавсралт 10. Төслийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны 2024 оны тайлан

Хавсралт 11. Төслийн 2024 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт

Хавсралт 12. Төслийн 2024 оны томилолтын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт

Хавсралт 13. Төслийн 2024 оны гэрээний хэрэгжилтийн тайлан

Хавсралт 14 Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ХШҮ хийх үнэлгээний матриц

1. ХУРААНГҮЙ

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журмыг батлах тухай” 176 дугаар тогтоолтой холбогдуулан Сангийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 193 дугаар тушаалын хавсралт маягтын дагуу БОУАӨЯ-ны хэрэгжүүлж буй “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох II” төслийн 2024 оны Хяналт-шинжилгээний тайланг жилийн эцсийн байдлаар гаргалаа. *(Хавсралт 1. Сангийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 193 дугаар тушаалын хавсралт маягт 15)*

Энэхүү тайланд төсөлд оруулах шаардлагатай өөрчлөлт, түүний үндэслэл, 2024 оны үйл ажиллагааны үнэлгээ, үнэлгээний аргачлал, төсөл, арга хэмжээний орчны өөрчлөлт, таамаглал ба эрсдэл үүсэх магадлал, тэдгээрийн төсөл, арга хэмжээнд үзүүлэх нөлөө, нийцтэй байдал ба тогтвортой байдал, хэрэгжилтийн үр ашгийн үнэлгээ, дүгнэлт болон үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж, саналуудыг тусгасан болно.

2. ТӨСӨЛД ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газрын хоорондын Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны 2016 оны хэлэлцээрээр төслийн II шатыг ТХГН-ийн Баруун бүсэд 19.5 сая еврогийн, 2017 оны хэлэлцээрээр III үе шатыг Говийн бүсэд 8 сая еврогийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлэхээр тус тус шийдвэрлэсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газар (түүнийг төлөөлөн Байгаль орчин, аялал жуулчлалын яам), Германы Засгийн газар (түүнийг төлөөлсөн ГСБЗ/ KfW банкны) хооронд 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр болон 2019 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Тусгай гэрээг тус тус байгуулсан. *(Хавсралт 2. Төслийн II,III шатны Засгийн газар хоорондын хэлэлцээр, санхүүжилтийн гэрээ болон Тусгай гэрээ)*

Төслийн үндсэн баримт бичиг болох “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл хэрэгжүүлэх Тусгай гэрээ бөгөөд дээрх гол баримт бичгийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолын дагуу батлагдсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэл, тайлагнах” журамтай давхар мөрдөж ажилладгаараа Монгол Улсад хэрэгжиж буй олон улсын бусад төсөл хөтөлбөрөөс онцлог болно.

БОУАӨ-ийн сайдын 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр баталсан удирдамжийн дагуу төслийн санхүүжүүлэгч байгууллага болох ХБНГУ-ын Сэргээн босголт зээлийн (KfW) банкны төслийн менежер Лидия Примаченкогийн ахалсан явцын үнэлгээний баг нь Монгол Улсад айлчилж, тус яамны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Д.Батцогт, тус банкны техникийн ахлах инженер Маттиас Бэхтолсхайм, Монгол дахь багц төслийн

зохицуулагч Г.Эрдэнэбаясгалан болон төслийн зөвлөх баг болон Төсөл хэрэгжүүлэх нэгжийн төлөөллийн хамт 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд төслийн явцын үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэсэн.

Үнэлгээний үеэр БОУАӨ-ийн сайд, тус яамны ТНБД буюу төслийн удирдах хорооны дарга, ТХГНБХГ-ын дарга буюу төслийн захирал, Сангийн яамны холбогдох удирдлага, албан тушаалтнуудтай уулзаж, төсөлд оруулах шаардлагатай өөрчлөлт бүхий доорх асуудлыг хэлэлцэж, хоёр тал хурлын тэмдэглэлээр албажуулсан болно. Үүнд:

1. **Төслийн I үе шатыг 2013-2022 онуудад амжилттай хэрэгжиж дууссан** гэж үзэн тус шатны **тусгай дансыг хаасан**, ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яаманд энэ үе шат дууссаныг албан ёсоор мэдэгдсэн.
2. Төслийн I шатны ОБЗЭС-ийн анхны үр дүн нь (ялангуяа бэлчээрийн доройтлыг бууруулахад үзүүлэх нөлөө) ноцтой эргэлзээ төрүүлж байгааг харгалзан үнэлгээний багийн зүгээс одоогийн арга барилд тохируулга хийж өөрчлөх хэрэгцээ шаардлага байгааг онцлон тэмдэглэж, **ОБЗЭС-гийн үйл ажиллагааг түр зогсоохоор шийдвэрлэсэн**.
3. Төслийн II, III шат эхлээд 4 жил өнгөрч байгаа хэдий ч буцалтгүй тусламжийн нийт 27,5 сая еврогийн хөрөнгө оруулалтын дөнгөж 40 орчим хувийг зарцуулсан. Хэдийгээр 2020-2022 онуудад төслийн I болон II,III шатыг давхар хэрэгжүүлж ачаалал их байсан ч, Ковидын нөхцөл байдал нөлөөлсөн ч, мөн төслийн эхний жилүүдэд бодит хөрөнгө оруулалтаас илүү төслийн бэлтгэл ажил болох суурь үзүүлэлтийг тодорхойлох зэрэг судалгааны ажлууд хийгдсэн ч 2023-2024 онуудад нийт төсөвлөсөн мөнгөний тус тус 40 орчим хувь л зарцуулагдсан байгаа тул зарцуулалтыг хугацаатай харьцуулсны дагуу төслийн хэрэгжилтийг хангалтгүй гэж үнэлэн, **Төслийн III үе шатыг IV үе шаттай хамт хэрэгжүүлэхээр хойшлуулснаар 2020-2027 онуудад оруулах байсан 27,5 сая еврогийн хөрөнгө оруулалт 19,5 сая евро болсон.** (*Хавсралт 3. Төслийн 2023-2024 оны худалдан авах ажиллагааны болон үйл ажиллагааны тайлан*)
4. Төслийн үйл ажиллагаа урт хугацааны стратеги дээр суурилагагүй, цаашилбал, БОЯБХУАӨДЗ төслийн бодит хэрэгжилт нь Тусгай гэрээний заалттай бүрэн нийцэхгүй байна гэж үзэн нэн даруй засаж залруулах шаардлагыг үндэслэн төслийн ЗБ-ын дэмжлэгтэйгээр **стратегийн баримт бичгийг шинэчлэн бүрэлдэхүүн тус бүрийн үндсэн үйл ажиллагааг дахин боловсруулахаар** тохирсон. (*Хавсралт 4. ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны тайлан, албан бус орчуулга*)
5. Төсөл дууссанаас хойш тогтвортой, урт хугацааны хөрөнгө оруулалт болгож үлдээх зорилгыг чухалчлан KfW-ийн үнэлгээний баг болон БОУАӨЯ нь III үе шатыг дахин төлөвлөх, шинэ IV үе шатыг боловсруулах стратегийн хувилбаруудыг тодорхойлох зорилгоор **БОЯБХУАӨДЗТ-ийн үнэлгээ,**

судалгааг 2025 оны эхний улиралд хөндлөнгийн зөвлөхөөр хийлгэхээр тохиролцсон. Төслийн III үе шатыг дахин төлөвлөснөөр одоо үйлчилж байгаа 2019 оны 6-р сарын 26-ны өдрийн Тусгай гэрээнд засвар хийх шаардлага гарна.

6. ТХН-ийн орон тооны бүтцийг Тусгай гэрээний заалтын дагуу болгох ТХН-д мэргэжлийн удирдлага шаардлагатай байгааг тодорхойлсон. (Хавсралт 5. ТХН-ийн удирдлагын мэдээлэл)

Үүнд: Тусгай гэрээнд заасны дагуу төслийн ТХН-ийн зохицуулагч болон зөвлөх багийн удирдлагыг солих, Тусгай гэрээнд байхгүй Сургалт, судалгаа, хэвлэл мэдээллийн ажилтны орон тоонд ажилтан томилохгүй байх, хуульчийг ТХН-ийн бүтцэд оруулж болох, худалдан авалтын ажилтны сул орон тоог яаралтай нөхөх шаардлагатай талаар хоёр тал санал нэгдсэн. (Хавсралт 6. Төслийн II шатны Бүтэц орон тооны Тусгай гэрээний заалт, шийдвэр)

7. Төслийн нийт хөрөнгө оруулалтын дөнгөж 40 хувь нь зарцуулагдсан байхад ЗБ-ийн төсвийн 60 гаруй хувь зарцуулагдсан байгаа тул олон улсын мэргэжлийн түвшинд нэмэлт зардал гаргахгүй байх, ЗБ-ийн үндсэн зөвлөхүүд нь тухайн салбарын мэдлэг чадвартай байхын зохицуулалттай өөрчлөлтийг зөвлөх үйлчилгээний гэрээнд оруулахыг үүрэг болгосон.
8. Төслийн логфрэймийн нөлөөлөл/төслийн зорилтууд, урт хугацааны үр дүн/төслийн зорилтууд болон богино хугацааны үр дүнг тогтмол шинэчлэх шаардлагатай холбогдуулан ЗБ-ийн дэмжлэгтэйгээр одоогийн явцын тайлангийн матрицаас гадна үр дүнгийн мониторингийн матриц боловсруулна.
9. Тендерийн баримт бичгийг англи хэл рүү мэргэжлийн орчуулагчаар цаг тухайд нь орчуулуулах шаардлагатай байгааг онцолсон. (Хавсралт 7. KFW банкны 2024 оны 10 дугаар сарын 20-ноос 11 дүгээр сарын 02-ны өдрүүдэд хийсэн мониторингийн үнэлгээний хурлын тэмдэглэл), (Хавсралт 8. KFW банкны явцын үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө)

3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

3.1 Өнөөгийн хэрэгцээтэй тохирч буй байдал буюу хамааралтай байдал

2024 он нь Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой тохиосон онцлог жил байсан.

2024 оны 09 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан Монгол, Германы хөгжлийн бодлогын зөвлөлдөх уулзалтын үеэр талууд хоёр улсын хөгжлийн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл болох биологийн олон янз байдал ба байгаль хамгаалах хүрээнд цаашид хамтран ажиллах механизм, мөн хэрэгжүүлэх төслүүдийг Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж хэрэгжүүлэхээр тохирсон.

2024 оны 08 дугаар сарын 14-ний өдөр БОУАӨ-ийн сайд С.Одонтуяа Элчин сайд Кулитцийг хүлээн авч уулзах үеэр стратегийн түвшний хамтын ажиллагаанд байгаль орчны салбар маш чухал байр суурь эзэлж байгаа тул байгаль орчны хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр онцгойлон анхаарахаа герман тал илэрхийлсэн.

Төслийн II, III шат хэрэгжих Баруун болон Говийн бүсийн ТХГН-ийн биологийн олон янз байдлыг хамгаалах, ой болон бэлчээрийн тогтвортой байдлыг хангах, хамгаалалтын захиргаануудын менежментийг сайжруулах, тэдгээрийн орчны бүсийн дэд бүтэц, иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлийн хөрөнгө оруулалтууд төлөвлөгдсөн болно.

Монгол, Германы хөгжлийн бодлогын 2024 оны зөвлөлдөх уулзалтын үеэр төслийн IV шатыг 10 сая еврогийн санхүүжилттэйгээр хэрэгжүүлэх яриа хэлцлийг эхлүүлсэн.

3.2 Төсөл арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө

Төслийн үндсэн баримт бичигт тусгагдсанаар төслийн үр нөлөөллийн дараах дөрвөн үндсэн шалгуур тавигдсан. Үр нөлөө нь хамгаалж буй БОЯБ-ын тоо хэмжээний өсөлт бууралт, үйл ажиллагааны тогтвортой байдал, иргэдийн байгаль хамгааллын мэдлэг, чадварын өсөлт, судалгааны давтамж, удирдлагын боловсронгуй байдлаар илэрнэ.

Зураг 1: Төсөл арга хэмжээнээс хүлээгдэж байгаа үр нөлөө

Төслөөс гарах үр дүн



Төслөөс гарах үр дүнг тодорхойлох хугацаа, нэгж, давтамж, суурь үзүүлэлт, зорилтот утга, өнөөгийн байдлын талаарх мониторингийн матриц, нэгдсэн төлөвлөгөөг 2024 оны 05 сард төслийн зөвлөх багаас эцэслэн боловсруулж, санхүүжүүлэгчээр батлуулсан. Төслийн I, II, III үе шатуудыг хамарсан бүхий мэдээллийн санг бий болгож, мониторингийн сургалтыг төслийн зөвлөх багаас 2025 оны эхний улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.

Мөн төслийн III шатыг дахин төлөвлөх, IV үе шатны стратегийн хувилбаруудыг тодорхойлох зорилгоор БОЯБХУАӨДЗ төслийн үр дүнд хөндлөнгийн үнэлгээг хийхээр KfW-ийн үнэлгээний багийн 2024 оны ажлын үр дүнд тохиролцсон.

3.3 Төсөл арга хэмжээний зорилтын биелэлт, үр дүнтэй байдал

Төслийн 2024 оны үйл ажиллагааг төлөвлөхдөө төслийн захиалагч тал болох БОАЖЯ-ны нийт 7 газар хэлтсээс ажлын санал авсан. Үүнд: Нийт ирүүлсэн 33 ажлын саналаас Уур амьсгалын өөрчлөлт, бодлого төлөвлөлтийн газар (12), Байгалийн нөөцийн бодлого зохицуулалтын газар (7), Хүрээлэн буй орчны бодлого зохицуулалтын газар (4), Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газар (4), Төрийн захиргааны удирдлагын газар (4), Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсээс 1 санал, Сайдын алба/ зөвлөх (1) санал хүргүүлсэн.

Зураг 2: Төслийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэх ажлуудын захиалагч талын санал

БОУАӨЯ-наас ирүүлсэн ажлын санал

Боломжтой
санал
6

- ТХГ-ын менежментийн төлөвлөгөөг боловсруулах (Сайдын алба).
- Байгальд зэлтэй малчид, малчдын бүлгийг дэмжих зээлийг үргэлжлүүлэн олгох (УАӨБТГ).
- Бохир соруулдаг машин нийлүүлэх (УАӨБТГ).
- БО-ны өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх (ТЗУГ).
- Байгаль хамгаалагчдад биологийн олон янз байдлын мониторингийн судалгааны арга зүйд сургах сургалт (БНБЗГ).
- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарыг чадавхижуулах гадаад улсад туршлага судлуулах (АЖБЗГ) зэрэг болно.

Санхүүжүүлэгч
байгууллагад
танилцуулж,
хэлэлцэх,
концепцийг
боловсруулах
шаардлагатай
ажил
10

- УТХГ-т жуулчдын гол зорин очдог байршилд хуурай технологийн аргаар АЦБ-ийг байгуулах (УАӨБТГ).
- Хог шатаах дэвшилтэд технологи бүхий зүүхыг нийлүүлэх (УАӨБТГ).
- Төлөвлөгөөний төслийг Даян дэлхийн 250 он хүртэлх БОЯБ-ын баомит бичиг болох бусад олон улсын хэмжээнд даган мөрдөх үүрэг бүхий чиг санаатай үйлдүүлэн тусгайлсан байдлаар төлөвлөх жишиг гаргах (ТЗУГ).
- Шинээр орох хамгаалалтын захиргаадад тогтвортой санхүүжилтийг үйл ажиллагааг эхлүүлэх, мэдээлэл мэдлэг тараах боломж бүхий хосолмол ашиглалтын төв байгуулах (ТЗУГ).
- Тусгай сонирхолын аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд дэд бүтцийг хөгжүүлэх /шувуу ажиглах цэг, нүүвч сүлдэрвч/ (АЖБЗГ).
- Аймгийн БОАЖГ-ыг компьютер, түүвх чадвар сайтай авто машин гэх мэт тоног төхөөрөмжөөр хангах (АЖБЗГ).
- БО-ны чиглэлийн нэмэлт өөрчлөлт болон шинэчилсэн найруулгаар батлагдсан хууль болон дагалдан гарсан журмыг БО-ны байгууллагуудад сургалт зохион байгуулах (БНБЗГ).
- Цөцгилтэд өртсөн газар нутгийг нөхөн сэргээх байгалийн ургамлын үр, тарьж ургуулах талбай байгуулах (БНБЗГ).
- Хөрсний бохирдол, ариун цэврийн байгууламж, хог хаягдлын чиглэлээр орон нутгийн орчны бохирдлын асуудал харилцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах, сургалтад хамруулах (ХБӨБЗГ).
- Аймаг, сумдын төвлөрсөн хог хаягдлын цэглэх, дарж булах, хашаалах жишиг зураг төсөв боловсруулах (ХБӨБЗГ) зэрэг болно.

Боломжгүй
санал
17

Төслийн зорилтот бүлэг биш
БОУАӨЯ-гаас хэрэгжүүлэх "Тогтвортой аялал жуулчлалын төсөл"-тэй давхацсан ажлыг хязгаарласан
Санхүүгийн хамтын ажиллагааны төсөл учир техникийн хамтын ажиллагааны ялгаа Төслийн I шатны
хүрээнд хэрэгжүүлчихсэн 3 ажил

Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт

Төслийн хүрээнд 2024 онд нийт 67 үйл ажиллагааг төлөвлөж, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Удирдах хорооны хурлаар хэлэлцүүлж, төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан.

Нийт 67 ажил төлөвлөснөөс төслийн бүрэлдэхүүн хэсгээр авч үзвэл: Төслийн ерөнхий менежментийн 3 ажил, бүрэлдэхүүн хэсэг 1-ийн 8 ажил, 2-ын 21 ажил, 3-ын 15 ажил, 4-ийн 11 ажил, БОНМ-ийн 3 ажил, ТХН-ийн дотоод 6 ажил байна.

Нийт 67 ажлаас тогтмол төлөвлөгддөг 8 ажил, шинээр төлөвлөсөн 20 ажил, 39 ажил он дамжсан ажлууд байна.

Он дамжсан 39 ажлаас 15 ажил гэрээ байгуулагдсан, 24 ажил дахин төлөвлөгдсөн. (Барилгын хэрэгцээ шаардлагын судалгаанууд, үзэл баримтлал, концепц боловсруулах, ОБЗЭС-гийн санхүүжилтийн ажил зэрэг 2023 онд хэрэгжээгүй ажлууд)

Нийт 67 ажлаас, Барилгын 3 ажил /2.18+ 2.19+3.15/, Загвар төсөл 3 ажил /2.09+2.10+3.09/, Бараа нийлүүлэх 17 ажил Зөвлөх үйлчилгээ үзүүлэх болон чадавхыг бэхжүүлэх, хэрэгцээ шаардлагын судалгаа хийх зэрэг бусад 44 ажил байна.

Тус 44 ажлыг ангилбал төслийн менежментийн 3 ажил, үзэл баримтлал боловсруулах 12 ажил, зөвлөхийн 13, зөвлөхийн бус 10, сургалт 3, БОННМ 3 ажил тус тус төлөвлөгдөөд байна. Нийт 67 ажлаас /үзэл баримтлал боловсруулах зэрэг/ нийт 11 ажлыг зөвлөх баг гүйцэтгэхээр төлөвлөгдсөн.

Зураг 3: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн үйл ажиллагааны хэрэгжилт (жилийн эцсийн байдлаар)



Хүснэгт 1: Төсөл арга хэмжээний биелэлт (зорилт тус бүрээр)

Үйл ажиллагааны зорилтууд	Үйл ажиллагааны төрөл				Ажлын тоо	Үнэлгээ Биелэлт %
	Он дамнасан	Тендер	Зөвлөхийн үйлчилгээ	Зөвлөхийн бус		
Зорилт 1	1	4	3	-	8	60
Зорилт 2	6	10	4	1	21	53,5
Зорилт 3	5	6	3	1	15	59,3
Зорилт 4	2+1	2	1	5	11	67,8
Ерөнхий менежмент	-	-	-	3	3	83,3
БОННМ, Мониторинг	-	1	2	-	3	30
ТХН, ЗБ-ийн зардал	1	2	2	1	6	100
Дүн	16	25	15	11	67	64,8

БОЯБХУАӨДЗ төслийн үйл ажиллагааны хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар арифметик дунджаар 64,8 %-ийн биелэлттэй байна. (Хавсралт 9. Төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, үйл ажиллагааны 2024 оны тайлан)

Хүснэгт 2: Төсөл арга хэмжээний үр дүнтэй байдал

Төсөл арга хэмжээний үр дүнтэй байдал	Ажлын тоо	Үнэлгээ %
Үр дүнтэй, бүрэн хэрэгжиж дууссан	24	100%
Өөрсдөөс хамаарах шийдвэр гарсан, гэрээ хэрэгжих шатандаа	14	70%
Боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, гэрээ байгуулагдах шатандаа	8	50%
Боловсруулалтын шатандаа, гэрээ байгуулагдах шатандаа	4	30%
Үр дүнгүй, хэрэгжээгүй	12	0
Цуцлагдсан, үнэлээгүй	5	-
Дүн	67	64,8

2024 онд төлөвлөсөн нийт 67 ажлаас 24 ажил 100% (бүрэн хэрэгжсэн), үүнээс 18 ажил 2023 оны, он дамжсан ажил бол 6 ажил 2024 онд эхэлсэн ажил болно.

3.4. Үр дагаварт хүрч буй байдал, үйл ажиллагаануудын хэрэгжилт

Зураг 4: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн үйл ажиллагааны төрөл, хэрэгжилтийн төлөв (жилийн эцсийн байдлаар)



Нийт төлөвлөсөн 67 ажлаас 12 ажил хэрэгжээгүй нь зээлийн эргэлтийн сангийн 4 ажил зээлийн эргэлтийн сангийн журмаас шалтгаалан эхлээгүй тул 2025 онд концепцийг үзэл баримтлалын хамт боловсруулж, санхүүжүүлэгч байгууллагаас зөвшөөрлийг авч, сангийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд анхаарч ажиллах нь чухал байна.

Мөн төслийн хүрээнд барих Говийн их ДЦГ-ын хамгаалалтын захиргааны байр барих, байгаль хамгаалагчийн байр барих, нийт 3 ажил барилгатай холбоотой байгааг дүгнэхэд барилгын ажлыг төлөвлөхдөө бэлтгэл ажлыг хангах, зураг төсвийн болон барилгын ажлыг нэг онд төлөвлөх нь буруу, төсөв болон биелэлтийн хугацааг бодитоор тооцоолох, ажлын даалгаврыг чанартай боловсруулахад анхаарах шаардлагатай байна.

Тайлангийн хугацаанд төлөвлөсөн ойн болон бэлчээрийн загвар төслийн 3 ажил мөн зөвлөх багийн ажлын даалгаврын боловсруулалт удааширсантай холбогдуулан эхлээгүй.

Мөн чадавхжуулах чиглэлээр төлөвлөсөн туршлага судлах аялал зорилго нь тодорхой биш, мониторингийн сургалт олон улсын зөвлөхийг монголд ажиллах томилолт хойшилсонтой_холбогдуулан 2025 он руу шилжиж хэрэгжихээр болсон тул дээрх арга хэмжээний хэрэгцээ шаардлага, зорилго, үр дүн, оролцогч нарыг зөв тодорхойлох нь чухал байна.

2024 онд төлөвлөсөн нийт 67 ажлаас 40 ажил 2025 он руу он дамжиж хэрэгжихээр хойшилсон.

Зураг 5: 2024 оны хэрэгжээгүй үйл ажиллагаанууд (жилийн эцсийн байдлаар)



Төслийн 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт

Төслийн хүрээнд 2024 онд нийт 23 худалдан үйл ажиллагааг төлөвлөж, 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Удирдах хорооны хурлаар хэлэлцүүлж, төслийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулсан. Үүнд: Нийт 23 ХАА төлөвлөснөөс ангилж авч үзвэл: Ажил 2, бараа 6, зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ 15 байна.

Бараа нийлүүлэх 6 ажлаас үндсэн болон судалгааны тоног төхөөрөмж, дүрэмт хувцас, цаг уурын автомат станц, таблет, гар утас болон ТХН-д шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэхээр төлөвлөгдсөн.

Зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээний 15 ажлаас барилгын зураг төсөв боловсруулах 1, БОНН-ийн 1, хэрэгцээ шаардлага боловсруулах 3, сургалт

зохион байгуулах 2, загвар төсөл хэрэгжүүлэх 5 зөвлөх үйлчилгээ болон хэвлэлт, орчуулга, архив зэрэг зөвлөхийн бус 3 үйлчилгээ төлөвлөсөн.

Нийт 23 ХАА төлөвлөснөөс 12 тендер ҮНТШ, 3 тендер ХТШ, 8 тендер ГШБ журмаар зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн.

Зураг 6: Төслийн II, III шатны Худалдан авах ажиллагааны биелэлтийн нэгтгэл (он оноор)



БОЯБХУАӨДЗ төслийн худалдан авах ажиллагааны хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар арифметик дунджаар 57,8 %-ийн биелэлттэй байна.

Зураг 7: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн худалдан авах ажиллагааны хэрэгжилт (жилийн эцсийн байдлаар)



2024 онд төлөвлөсөн нийт 23 тендерээс нийт 4 тендер цуцлагдсан тул үнэлээгүй. Үнэлсэн нийт 19 тендер: Үүнээс: амжилттай зохион байгуулагдсан 11 тендер тайлангийн хугацаанд гэрээ байгуулсан, 8 тендер 2025 он руу он дамжиж хэрэгжихээр хойшилсон. (Хавсралт 10. Төслийн 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны 2024 оны тайлан)

Төслийн 2024 оны Хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт

Төслийн хүрээнд 2024 онд хяналт-шинжилгээ, үнэлгээний нийт 16 ажлыг төлөвлөж, төслийн зохицуулагчид танилцуулсны дүнд 2024 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Төслийн 2024 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөг батлуулсан.

Хүснэгт 3: Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн ХШҮ-ний ажлын хэрэгжилт (жилийн эцсийн байдлаар)

ХШҮ-ний ажлын чиглэл	Ажлын тоо	Үнэлгээ
ХШҮ-ний ерөнхий менежмент	4	87.5%
Үр дүнд суурилсан ХШҮ хийх	4	87.5%
Төслийн баримт бичигт ХШҮ хийх	3	66.6%
Орон нутагт томилолтоор ажиллах	3	66.6%
Тайлан хүргүүлэх	2	100%
Дүн	16	81.6%

БОЯБХУАӨДЗ төслийн ХШҮ-ний ажлын хэрэгжилт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар арифметик дунджаар 81.6 хувийн биелэлттэй байна. (Хавсралт 11. Төслийн 2024 оны хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт), (Хавсралт 12. Төслийн 2024 оны томилолтын төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт)

Төслийн хүрээнд байгуулагдсан гэрээний мэдээлэл

Төслийн гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийхдээ 2023-2024 онуудад байгуулагдсан гэрээг авч үзсэн учир нь 2023 онд байгуулагдсан 10 гэрээ он дамжиж, 2024 онд хэрэгжиж дууссан. Харин тайлангийн хугацаанд буюу 2024 онд байгуулагдсан нийт 13 гэрээнээс бүрэн хэрэгжсэн 3 гэрээ, 2025 он руу он дамжиж хэрэгжих 10 гэрээт ажил байна.

Хүснэгт 4: Төслийн гэрээний хэрэгжилт

Гэрээний төлөв	2023 он	2024 он	Нийт
Байгуулагдсан гэрээ	10	13	23
Хэрэгжиж дууссан гэрээ	10	3	13
2025 он руу он дамжиж хэрэгжих			10
Гэрээний сунгалт	10	3	13
Гэрээний нэмэлт өөрчлөлт		2	2

(Хавсралт 13. Төслийн 2024 оны гэрээний хэрэгжилтийн тайлан)

3.4 Үнэлгээний зорилго, хэрэглэсэн арга зүй, сул тал

Тайлангийн хугацаанд төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл явцыг сайжруулах, шалгуур үзүүлэлтийг боловсруулах зорилгоор төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог /матрицыг шинэчлэн боловсруулсан.

Энэхүү матрицын дагуу хөтөлбөр, төслийн хэрэгжилт нь төлөвлөлтийн дагуу явж байна уу гэдэгт хяналт-шинжилгээ хийж, тухайн үйл ажиллагаа бүрийн явцыг тодорхойлохоос гадна тус тогтолцоо нь ТХН-ийн ажилтан, зөвлөх багийн үүрэг хариуцлага, ажлын хуваарилалт, үйл ажиллагааны явцын мэдээ бүрэн харагддагаараа давуу талтай.

Сул тал нь үнэлгээнд үр дүнгээс гадна чанарын буюу үр ашигт байдлыг тооцохгүй, зөвхөн гүйцэтгэлийг суурь болгодог тул үр ашигт байдлыг гаргаж ирэх тал дээр дутагдалтай. Үнэлгээний аргачлалыг боловсруулахдаа мөн ажлыг үе шат бүрээр нарийвчлан, үйл ажиллагааны шат дараалал бүрийг орхигдуулалгүй оруулахыг хичээж, хийгдэх ажлын тоо хэмжээ, ачаалал, зарцуулах хугацаа зэргийг харгалзан тооцож, үнэлгээнд эзлэх хувийг бодитой гаргахыг зорьсон болно. Үүнд:

Үнэлгээг хийхдээ үйл ажиллагааны үндсэн гурван чиглэлээр хийнэ.

1. Төслийн худалдан авах ажиллагааны бэлтгэл ажлыг үнэлэх. Хэрэгцээ шаардлагын судалгаа, үзэл баримтлал, загвар гаргах болон техникийн

тодорхойлолт, хуваарилалтын хүснэгтийг боловсруулах, ажлын даалгаврыг боловсруулах, батлуулах гэсэн үе шаттай.

2. Төслийн худалдан авах ажиллагааны явцыг үнэлэх. Худалдан авах ажиллагааны нийт 15 үе шатыг тус бүрийг тодорхойлсон тул бодит үнэлгээ гарсан гэж үзэж байна. Гэрээ байгуулснаар тус ажлыг 100 хувь гүйцэтгэлтэй гэж үзнэ.
3. Төслийн гэрээний хэрэгжилтийг үнэлэх. Гэрээний хэрэгжилтийг гэрээний гүйцэтгэлийн дагуу олгох санхүүжилтийн хуваарийн дагуу үнэлэгдэнэ. /Гэрээг дүгнэснээр тус ажлыг 100 хувь гүйцэтгэлтэй гэж үзнэ. Энэхүү үнэлгээнд Худалдан авах ажиллагаа 60 хувийг эзлэхээр тооцоолсон./

Үнэлгээний оноог өгөхдөө Засгийн газрын хяналт, шинжилгээ үнэлгээний аргачлалыг суурь болгон энгийн арифметик арга ашиглан тооцов.

(Хавсралт 14 Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд ХШҮ хийх үнэлгээний матриц)


Зураг 8 Үнэлгээний матриц, аргачлал

The table is a large matrix used for project performance evaluation. It features multiple columns and rows, with cells color-coded in blue, green, and red. The columns represent different project components and indicators, while the rows represent specific evaluation criteria. The matrix is organized into several sections, with some rows highlighted in red and others in blue. The table is titled 'M&E OP2024, Component 1-4, 5-6' and 'M&E OP2024, Consultancy'.

4. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ОРЧНЫ ӨӨРЧЛӨЛТ, ТААМАГЛАЛ БА ЭРСДЭЛ ҮҮСЭХ МАГАДЛАЛ, ТЭДГЭЭРИЙН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль 2024 онд зохион байгуулагдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу 126 гишүүнийг холимог тогтолцоогоор сонгосонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 07 сарын 24 өдрийн 06 дуугаар тогтоолоор зарим яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан. Үүнд:

Зураг 9: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны шинэчлэгдсэн бүтэц



Салбарын Аялал жуулчлалын чиг үүрэг Соёл, спорт, залуучуудын яам руу шилжиж, нийт 9 газар, 10 хэлтэстэй яам *Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам шинэчлэгдсэн*.

Байгаль орчны сайдын А/437 тоот тушаалаар шинэчлэн батлагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны бүтцийн орон тооны дээд хязгаар, Сургалт мэдээллийн төвийн байршлыг хэвээр үлдээв. 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн энэхүү тушаалаар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүждэг 34 хамгаалалтын захиргаанд удирдах ажилтан 34, удирдах албан тушаалтан 426, төрийн үйлчилгээний 267, төрийн үйлчилгээний 99 туслах ажилтан буюу нийт 826 үндсэн ажилтан ажиллаж байна.

2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдаар С.Одонтуяаг томилов. С.Одонтуяа нь байгаль орчны салбарыг хариуцсан Монгол Улсын 18 дахь, эмэгтэйчүүдээс сонгогдсон тав дахь сайд юм.

БОАЖЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл өөрчлөгдөж, 2024 оны 03 дугаар сард өмнө нь тус албан тушаалыг хашиж байсан Э.Баттулга буцаад томилогдон ажиллаж байна.

БОАЖЯ-ны Тусгай хамгаалалттай газар нутгийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Баатарцогт өөрчлөгдөж, 2024 оны 03 дугаар сард Д.Ганзоригийг томилсон бол 2024 оны 08 дугаар сард мөн өөрчлөгдөж, БОУАӨЯ-ны ТХГНБХГ-ын даргаар Д.Батцогт томилогдон ажиллаж байна.

Төслийн удирдах хороог Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны А/745 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан.

Мөн Тэнгис Шишгэдийн байгалийн цогцолборт газар, Ноён уулын ДЦГ-т тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын хоёр газрыг шинээр байгууллаа. Ингэснээр Тэнгис Шишгэдийн БЦГ-ыг Улаан тайгын УТХГ-ын хамгаалалтын захиргаанаас, Ноён уулын ДЦГ-ыг Хан Хэнтийн УТХГ-ын хамгаалалтын захиргаанаас тус тус шилжүүлсэн болно.

Тиймээс 2024 оны I улиралын байдлаар улсын тусгай хамгаалалттай газар нутгийг хянадаг 42 Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа (ТХГН) байна. Эдгээрээс улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 35 тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, 5 ТББ-ын хамт төрийн бус байгууллага, 1 хамгаалалтын захиргааг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, 1 хамгаалалтын захиргааг тус тус хариуцан ажиллаж байна. БОУАӨЯ нь хамтын ажиллагааны гэрээгээр ТББ, орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаар удирдуулж байна.

5. НИЙЦТЭЙ БАЙДАЛ БА ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

5.1 Стратегийн зорилготой нийцтэй байдал

Төслийн үйл ажиллагаа нь байгаль экологийн талаар төрөөс баримталж буй дараах бодлогын баримт бичгүүдийн стратегийн зорилго, зорилттой нийцэж байгаа болно.

Хүснэгт 5: Төсөл уялдан хэрэгжих бодлогын бичиг баримтууд

д/д	Стратеги, бодлого	Бодлогын холбогдох заалт
1	“Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр” (УИХ, 1998)	“Байгалийн унаган төрхийг хадгалах, экологийн тэнцлийг хангах, байгалийн баялгийг арвижуулах, байгаль, түүх, соёлын өвийг хамгаалах зорилгоор байгалийн бүс бүслүүрийн үндсэн шинж, иж бүрдлийг төлөөлсөн экологийн онцгой ач холбогдол бүхий газар нутгаар тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлж, нийт нутаг дэвсгэрийн 30-аас доошгүй хувьд хүргэнэ”
2	Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр	2030 он гэхэд экосистемийн үндсэн төлөөлөл тус бүрийн 30-аас доошгүй хувь, уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өвөрмөц экосистемийг бүхэлд нь тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнд хамруулж, менежментийг нь сайжруулах,

		2020 он гэхэд ТХГН-ийн хамгаалалтын захиргааны дэд бүтцийг сайжруулан, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлсэн байна. 2025 он гэхэд Биологийн олон янз байдлын талаарх шалгуур үзүүлэлтийг Үндэсний тооцооны системд нэвтрүүлж, холбогдох салбарын хөтөлбөрийн мониторинг үнэлгээний системд тусгах
3	Алсын хараа 2050 (ЗГ, 2019)	Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем зорилтын 6.1.5. Тусгай хамгаалалттай газар нутгийн дэд бүтэц, материаллаг баазыг бэхжүүлж, хамгааллын зохистой менежментийг хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Ногоон хөгжил- Эх байгаль ба анхдагч экосистем 6.1.2. Ургамал, амьтны тархац, нөөцийн судалгааг улсын хэмжээнд үе шаттай хийж нөөцийн өөрчлөлтийг шинэчлэн тогтоож, зохистой менежментийг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ. 6.2.2. Амьтан, ургамлын улаан дансыг шинэчлэх, шинээр бий болгож, ховордсон зүйлийн хамгааллын арга замыг тодорхойлж хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил 1.1.25. Сурах бичиг, сургалтын нэмэлт хэрэглэгдэхүүн, цахим болон зайн сургалтын хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангасан байхаар боловсруулж, түгээнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил- Шинжлэх ухаан, инновац 2.4.12. Судалгаа хөгжүүлэлтийн ажлын үр дүнд суурилсан шагнал, урамшууллын тогтолцоог бий болгоно. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд эзлтэй амьдрах орчин 2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. 2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана. 2.5.6. Ногоон байгууламжийн усалгаанд хур тунадасны болон саарал усыг бүрэн ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Гэр бүл 2.3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар өрхийн орлогыг тогтмол нэмэгдүүлнэ. 2.4.10. Аж үйлдвэрийн тэргүүлэх салбарт дэвшилтэт болон шинэ технологи, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгосон, нэвтрүүлсэн, нутагшуулсан аж ахуйн нэгжийг гааль, татвар, зээлийн бодлогоор дэмжинэ.

		Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга-Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес 3.3.15. Гарааны бизнес эрхлэгч залууст бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох цогц арга хэмжээг хэрэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ. /хурдасгуур хөтөлбөр, менторшип, co-work-ing space, түрээсийн хөнгөлөлт/ Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Амьдралын чанар ба дундаж давхарга - Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт 3.4.2. Барьцаа хөрөнгийн, зээл авах хүсэлтэй бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд Засгийн газрын зүгээс санхүүжилтийн баталгаа гаргах үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хүнд ээлтэй амьдрах орчин 2.5.20. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтворжуулах, хүнсний сүлжээний бүх шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хүнсний салбарын стандартуудыг олон улс, бүс нутаг, гадаад орны дэвшилтэт стандартад хүргэхэд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Алсын хараа 2050-Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлалын Хүний хөгжил-Хөдөлмөрийн зах зээл 2.6.15. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, гадаад иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудлыг хүн амын аюулгүй байдлыг хангах болон мэргэжлийн өндөр ур чадвар, технологийг хөдөлмөрийн зах зээлд нутагшуулах бодлоготой уялдуулна.
--	--	--

5.2 Бодлогын орчин

Монгол орны байгалийн олон төрлийн бүс, бүслүүр нь зэрлэг амьтан, ургамлын олон төрөл зүйлийн амьдрах орчныг бүрдүүлж байдаг. Эдгээр биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээ нь Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёлын болон хөгжлийн үндэс нь юм. Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөр (2015-2025)-т ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалан хамгаалах зорилгоор 2030 он гэхэд хамгаалах шаардлагатай экологийн хувьд чухал ач холбогдолтой 215 газраас 63 байршлын 15,3 сая га газрыг улсын тусгай хамгаалалтад авч, ТХГН-ийн хэмжээг 30 хувьд хүргэнэ гэж заасан.

биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор Засгийн газраас нийт нутаг дэвсгэрийн 21 хувийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад аваад байна.

ТХГН-ийн сүлжээг хариуцсан агентлаг байгуулж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх тухай санал 2024 оны 06 дугаар сард захиалагч талаас гарч байсан. Энэ тохиолдолд Монгол Улсын ТХГН-ийн сүлжээний менежментийн бодлогыг боловсруулахад мэргэжлийн зөвлөгөө шаардлагатай болно.

Зураг 10 Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлого



5.3 Эдийн засаг, санхүүгийн үндэслэл

Төслийн II, III шат 2020-2027 онуудад нийт 27,5 сая еврогийн санхүүжилттэйгээр хэрэгжихээс 2024 оны жилийн эцсийн байдлаар 37 орчим хувь нь зарцуулагдсан байна. Нийт санхүүжилтийн үлдэгдэл 17.4 сая еврог төслийн үлдэгдэл хугацаа 2025-2027 онуудад зарцуулахаар тооцоолбол нэг жилд 5,8 сая орчим евро зарцуулахаар төлөвлөгдөхөөр байна.

Зураг 11 Төслийн санхүүжилтийн хуваарь, 2024 оны санхүүгийн гүйцэтгэл



5.4 ТХН-ийн боловсон хүчний асуудал


Тайлангийн хугацаанд төслийн орон тоо, хүний нөөцийн холбогдох өөрчлөлтүүд гарсан. Үүнд:

- ТХН-ийн худалдан авах ажиллагаа хариуцсан ажилтан халагдсан. /2024.03 сард/,
- ТХН-ийн санхүү хариуцсан ажилтан халагдсан. /2024.03 сард/,
- Германы сэргээн босголт, зээлийн банкны төв, Франкфурт хотын (KfW) банкны Монгол дахь төсөл хөтөлбөрийг хариуцсан менежер Нина Отто солигдож, Лидия Примаченко томилогдсон. /2024.05 сард/,
- Төслийн зөвлөх багийн худалдан авах ажиллагаа хариуцсан зөвлөх ажлаа өгсөн. /2024.05 сард/,
- ТХГНБХГ-ын дарга, төслийн захирал 2 удаа өөрчлөгдсөн. /2024 оны 03 болон 08 сард/,
- ТХГНБХГ-ын төсөл хариуцсан мэргэжилтэн /2023.03 болон 08/,
- ТХН-ийн БОННМ хариуцсан ажилтан, /2023.09 сард/,
- Төслийн удирдах хорооны дарга, БОАЖ-ын дэд сайд М.Ганбаатар солигдож, тус яамны ТНБД Э.Баттулга томилогдсон. /2024 оны 10 сард/,
- Төслийн зөвлөх багийн орчуулагч ажлаа өгсөн. /2023.11 сард/,
- ТХН-ийн жолооч ажлаа өгсөн. /2023.12 сард/ зэрэг болно.

Тайлангийн хугацаанд ТХН-ийн бүтэц орон тооны хувьд дараах асуудлууд зөрчилтэй байсан. Хуулийн ажилтны гэрээ 2022 оны 12 сараар дуусгавар болсон ч 2023-2024 онуудад хуулийн ажилтангүй ажилласан. Тусгай гэрээнд байхгүй хуулийн фирмийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. /2024.08 сард/

ТХН-д батлагдаагүй орон тоо гаргаж, барилгын инженер 1 удаа, Сургалт, судалгаа, хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан 2 удаа томилсон. /2024.05 болон 08 сард/

Зураг 12: Төслийн бүтэц орон тооны шийдвэр, сул олон илүү орон тооны мэдээлэл



5.5 Нийгэм-соёлын асуудал

Төслийн хэрэгжиж буй газар нутгийн хувьд баруун болон говийн бүс нутгийн аймгуудыг хамарч байна. Тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүс дэх амьдарч буй бүх л нийгмийн давхаргыг хамарч, ямар нэг байдлаар иргэдийн зан заншил, соёлоор ялгаварлах үзэлгүйгээр тэгш хүртээмжтэй үр дүнг бий болгох нь баримтлах зарчмуудын нэг. Төслийн II, III шатны хүрээнд ТХГ-ын орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих санхүүгийн арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна. Мөн дээр нь орчны бүсийн сумдын иргэдийн боловсролын болон эрүүл мэндийн салбарт тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө оруулалтын туслалцаа үзүүлэн ажиллаа. Үүнд: Тусгай хамгаалалттай газар нутгийн Орчны бүсийн сумдын сургуулийн эко кабинет байгуулах тавилга, компьютер, тоног төхөөрөмжөөр хангах, орчны бүсийн сумдыг эмнэлгийн түргэн тусламжийн машинаар хангах зэрэг ажлууд болно.

5.6 Оролцоо ба өмчлөл

Оролцоо: Одоогоор байгаль орчны салбарт хандивлагчдын дэмжлэгтэй 20 төсөл хэрэгжиж байгаа бөгөөд тэдгээр байгууллагуудтай тодорхой зорилтот бүсүүдийн хүрээнд хамтран ажилладаг. Тайлангийн хугацаанд төсөл нь WWF, SPACES, ITG, ENSURE төслүүдтэй дараах чиглэлээр хамтран ажилладаг.

- Говийн Их "Б" ДЦГ-ын хамгаалалтын захиргааны байрны барилгын хүрээнд ITG-тэй хамтран ажиллаж байна.
- WWF, ITG, TNC-ийн дэмжлэгтэйгээр ТХГН-ийн удирдлагын төлөвлөгөөг сайжруулах,
- SPACES бүхий ТХГН-ийн хамгаалалтын бүсэд хог хаягдлын менежментийн хэрэгцээг үнэлэх,
- GIZ-тэй жижиг зээл зээлдэгчийн туршлага солилцох,

- SPACES-ийн STREAM бүрэлдэхүүн хэсэгтэй зэрэгцэн ойн ангиудыг тоног төхөөрөмжөөр дэмжих,
- Орчны бүсийн иргэдийн амьжиргааг дэмжих ажлын хүрээнд бяслагийн үйлдвэрийн анхны ТЭЗҮ-ийг GIZ-тэй хамтран боловсруулна.
- Байгаль хамгаалагч бэлтгэх арга барилыг GIZ-тэй хамтрахаар төлөвлөсөн.

Өмчлөл: Аливаа нэгэн техникийн туслалцаа үзүүлж байгаа нь цаанаа тухайн үйл ажиллагааг цаашид тогтвортой байдлыг бий болгох, суурь үр дүнг сайжруулах зорилготой байдаг. Төслийн хүрээнд оруулсан хөрөнгө оруулалтын үр дүнг нэмэгдүүлэхэд өмчлөлийн асуудал маш чухал. Нийлүүлсэн эд хөрөнгийг хөрөнгийг бүртгэх, ашиглах, тайлагнах, хяналт тавих, хариуцлага тооцох болон бусад харилцааг “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах” Сангийн сайдын 131 тоот журмын дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллаж байна.

5.7 Жендер

Тус төсөл нь санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж байгаа төсөл бөгөөд 2024 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд жендерийн ажил хийгдээгүй болно.

5.8 Байгаль орчин

Тайлангийн хугацаанд БОННМ-тэй холбоотой доорх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн. Үүнд: Эрээн нуурыг нөхөн сэргээх ажил нь Монгол Улсын Засгийн газраас санхүүжүүлснээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар нь барилгын ажлын гэрээ байгуулж, биологийн төрөл зүйл, сөрөг нөлөөг бууруулах стратегийн чиглэлээр дэмжлэг хүссэний дагуу БОНН-ийн үнэлгээг хийхэд төслийн зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан. Төслийн хүрээнд 2024 онд төлөвлөсөн хог хаягдлын менежментийн ТЭЗҮ-д төслийн БОННМ-ийн баг хамтран санал өгсөн.

5.9 Тохиромжит технологи

Төслийн хүрээнд хийгдэх хөрөнгө оруулалт шууд болон шууд бусаар хүрээлэн буй орчиндоо эерэг нөлөө үзүүлэх чиглэлийг баримталж ажилладаг. Энэ нь нэг талаараа мэргэжлийн байгууллагуудын судалгаа шинжилгээ, мониторингийн ажилд дэмжлэг үзүүлж, боловсон хүчний чадавх, ажиллах орчныг сайжруулах, нөгөө талаар орчны бүс дэх иргэдийн амьжиргааг дэмжих, байгаль орчинд ээлтэй бизнесийг дэмжихэд анхаарч ажилладаг.

6. ХЭРЭГЖИЛТИЙН ҮР АШГИЙН ҮНЭЛГЭЭ

Төслийн үр ашгийн үнэлгээг дараах байдлаар гаргаж дүгнэдэг. Үүнд:

- УХ-ны хурал (жилд 1-3 удаа);

- Үнэлгээний хорооны хурал (тендер бүрд)
- ТХН-ийн явцын мониторингийн үнэлгээ (үйл ажиллагаа тус бүрээр)
- Аудитын үнэлгээ (жилд 1 удаа);
- Дунд хугацааны үнэлгээ (улирал тутам);
- ГСБЗБ-ны явцын үнэлгээ (жилд 1 удаа);
- ГСБЗБ-ны явцын үнэлгээний протоколын биелэлт (хагас жил тутам)
- Төслийн үйл ажиллагааны тайлан (БОАЖЯ-ны УАӨГ, ГХАГ-т хагас жил тутам)
- Төслийн худалдан авах ажиллагааны тайлан (БОАЖЯ-ны НХБЗГ-т хагас жил тутам)
- Төслийн хяналт, шинжилгээний тайлан (СЯ-нд жил тутам)
- Төсөл хэрэгжилтийн тайлан (ГСБЗБ-нд хагас жил тутам, ЭКО КОНСАЛТ Зөвлөх компанид улирал тутам)
- Шилэн дансны тайлан мэдээ (сар тутам)
- Үр дүнд суурилсан Хяналт-шинжилгээ, үнэлгээний удирдлагын мэдээллийн нэгдсэн сан (ODAMIS)-гийн мэдээ (тухай бүрд)

Хүснэгт 6: Төслийг тайлагнах

Гадаадын тусламжийн төсөл, арга хэмжээг тайлагнах					
№	Тайлангийн төрөл	Журам	Хариуцах ажилтан	Хугацаа	Хэнд хүргүүлэх
1	Үйл ажиллагааны хэрэгжилтийн тайлан	Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Тусгай гэрээнд заасны дагуу	Зөвлөх баг	Улирал тутам	Германы Сэргээн босголт зээлийн банк (KfW)
2	Үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу	Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажилтан	Хагас жил тутам	БОУАӨЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар
3	Худалдан авалтын төлөвлөгөө, тайлан	Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 363 дугаар тушаалаар баталсан “ТБОНӨХБАҮХАА-г төлөвлөх, тайлагнах журам”	Худалдан авах ажиллагааны ажилтан нар	Сар тутам	БОУАӨЯ-ны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс
4	Санхүүгийн үйл ажиллагааны тайлан	Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралт	Санхүүгийн ажилтан	Хагас жил тутам	Сангийн яаманд

5	Хяналт, шинжилгээний тайлан, төлөвлөгөө	МУ-ын 3Г-ын 2016 оны “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах журмыг батлах тухай” 176 дугаар тогтоол, Сангийн сайдын 2016 оны 193 дугаар тушаалын хавсралт маягт	Хяналт- шинжилгээ, үнэлгээний ажилтан	Тухай бүр	Удирдах хорооны хурлаар танилцуулна Үр дүнд суурилсан ХШҮ-ний удирдлагын мэдээллийн нэгдсэн санд байршуулна
6	Ашиглалтын тайлан мэдээ НӨАТ-ын тайлан НД-ын шимтгэлийн тайлан ХАОАТ-ын тайланг		Санхүүгийн ажилтан	Сар бүр	БОУАӨЯ, СЯ баталгаажуулан KfW банканд Татварын ерөнхий газарт ХУД-ийн НД-ын хэлтэс, татварын хэлтэст

2.2. Эрсдэл үүсэх магадлал, тэдгээрийн төсөлд үзүүлэх нөлөө

Төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны төлөвлөгөөний хоёрт: “Үр дүнд суурилсан ХШҮ хийх” гэж заасны дагуу төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг хийж, зөрчил дутагдлыг арилгах талаар зөвлөмж өгөх, тайлагнах ажлын хүрээнд дараах асуудлуудыг анхаарч ажиллах талаар санал дэвшүүлж, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Хүснэгт 7: Төслийн хэрэгжилтийн ХШҮ, төслийн үйл ажиллагааг сайжруулахад анхаарах асуудал, санал зөвлөмж

Төслийн үндсэн бичиг баримт болох Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, БОАЖЯ, СЯ, KfW банк хооронд 2019.06.26-ны өдөр байгуулсан Тусгай гэрээ болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журмын заалтыг мөрдөн ажиллах тухай					
№	Зөрчил, авах арга хэмжээ	Тайлбар, тодруулга	Холбогдох бичиг баримт, мэдээлэл	Хавсралтын жагсаалт	Эх сурвалж
1.	Төслийн удирдлагыг томилохдоо мэргэжлийн бус, уул уурхайн салбарын хүн томилсон, төслийн зохицуулагчийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулаагүй	БОАЖ-ын сайд Б.Бат-Эрдэнэ-ний тушаалаар салбарын дэд сайд М.Ганбаатарыг Төслийн Удирдах хорооны даргаар 2022 оны 12 сард томилсон.	Үүнд: М. Ганбаатар- • БОЯБХУАӨДЗ төслийн УХ-ны дарга, БОАЖ-ын дэд сайд /2022-2024/ • “Таван толгой түлш” ХХК-ийн гүйцэтгэх захирал /2018-2022/ • Нийслэлийн МАН-ын хорооны дэд дарга /2013/ • Баянзүрх дүүргийн НИТХ-ийн гишүүн /2004-2012/	1. Төслийн удирдах хорооны даргыг томилсон тушаал 2. Холбогдох мэдээлэл	https://yellow.mn/n/3h https://ikon.mn/n/318s https://gogo.mn/r/497dm  Хавсралт CV_project coordina
	Авах арга хэмжээ: • ТХН-ийн ажилтан нарын шалгуур үзүүлэлт, баталсан ажлын даалгаврыг өөрлөхгүй байх; • Олон улсын төсөл хөтөлбөр дээр ажилласан туршлагатай, салбарын хүнийг сонгон шалгаруулах;	Төслийн зохицуулагчийн сонгон шалгаруулалтыг зарлаж, төслийн ХАА-ны зөвлөх Г.Солонго тэнцсэнийг хүчингүй болгож, ажлын байрны шалгуур үзүүлэлтийг өөрчилж дахин зарласнаар төслийн зохицуулагч нь БЗД-ийн МАН-ын XIV хорооны дарга, “Таван толгой түлш” ХХК-ний Үйлдвэрлэлийн албаны дарга М.Болдбаярыг томилсон.	Үүнд: М.Болдбаяр • БОЯБХУАӨДЗ төслийн зохицуулагч /2023-2024/ • Баянзүрх дүүргийн НИТХ-ийн гишүүн /2022-2024/ • “Таван толгой түлш” ХХК-ийн Үйлдвэрлэлийн албаны дарга /2018-2022/ • “Мөнхгэрэлтэх солонго” ХХК захирал /2012-2014/ • Австрали Айвэнхоу Майнз ХХК геологийн техникч /2006-2008/ • Оюу Толгой уурхайг туслан гүйцэтгэгч компанид нярав /2004-2006/ Боловсрол: Төмөр замын 20-р дунд сургууль /1989-1999/, Үндэсний их сургууль /2008-2012/ БНХАУ-ын Ардын Их сургууль /2015-2017/	1. Төслийн зохицуулагчийн шалгуур үзүүлэлт, баталсан ажлын даалгавар 2. Шалгуур үзүүлэлтийг өөрчилсөн зар 3. Зохицуулагчийн намтар, холбогдох мэдээлэл	https://livetv.mn/p/267328 https://www.facebook.com/BzdCouncil/videos/331562731800763/ https://mecc.gov.mn/sul-oron-toony-zar/bajgal-orchin-ayalal-zhuulchlalyn-yaamny-biologijn-olon-yanz-bajdlyg-hamgaalah-uur-amsgalyn-rchl-lt-d-dasan-zohicoh-ii-2016-67-054-2018-68-272-272-t-slijn-t-s-l-heregzh-leh-negzhid-t-slijn-zohicuulagch-huulijn-azhiltan-zholooch-shalgaruulzh-avna

№	Зөрчил, авах арга хэмжээ	Тайлбар, тодруулга	Холбогдох бичиг баримт, мэдээлэл	Хавсралтын жагсаалт	Эх сурвалж
	ТХН-ийн батлагдсан бүтэц орон тоонд хуулийн ажилтан гэж заасныг зөрчиж хуулийн фирмийг сонгон шалгаруулсан. <i>Авах арга хэмжээ:</i> Хуулийн фирм биш хуулийн ажилтныг сонгон шалгаруулах	Төслийн өдөр тутмын хэрэгжилтэд хуулийн зөвлөгөө өгдөг, гэрээ тушаал хянадаг ажилтан шаардлагатай болохоос улсаас цалин зардал нь гарах фирм шаардлагагүй.	2019.06.26-ны өдөр БОАЖЯ, СЯ, KfW банк хооронд байгуулсан төслийн Тусгай гэрээний 2.1.2, Сангийн сайд, БОАЖ-ын сайдын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 71, А/82 дугаар хамтарсан тушаалыг зөрчсөн.	4. Төслийн хуулийн ажилтны шалгуур үзүүлэлт, баталсан ажлын даалгавар 5. Хуулийн фирмийн сонгон шалгаруулалтын зар	 lawer шаардлага2024.pdf https://www.bacccp.mn/ad/det ail/95
	Батладаагүй орон тоог бий болгож, ажилтан томилсон <i>Авах арга хэмжээ:</i> Баталсан орон тоонд байхгүй ажилтан нарыг чөлөөлөх, баталсан орон тоогоор ТХН-ийг ажиллуулах	Сургалт, судалгаа, хэвлэл мэдээллийн ажилтны орон тоог бий болгож мэргэжлийн бус, цагдаа цэргийн салбарын тэтгэвэрт гарсан хүнийг ажилд авсан.		6. БОАЖЯ, СЯ, KfW банк хооронд байгуулсан төслийн Тусгай гэрээний Орон тоог тохирсон заалт /Х.6-7/ 7. Орон тоог баталсан Сангийн болон БОАЖ-ын сайдын хамтарсан тушаал	 Орон тоо.pdf  3. Bio 3 Separate agreement.pdf https://www.bacccp.mn/ad/det ail/72
	Орон нутагт нэг жолооч ажиллуулах заалтыг зөрчиж, Увс дахь жолоочийг үндэслэлгүйгээр халсан. <i>Авах арга хэмжээ:</i> Орон нутгийн автомашиныг буцааж, ХШҮ-ний ажлыг газар дээр нь хийх ажлыг эрчимжүүлэх	Шинээр жолоочийн сонгон шалгаруулалтыг авч, Улаанбаатарт ажиллуулж байна. Төслийн хэрэгжилтэд Улаанбаатар хотод хоёр машин шаардлагагүй, харин төслийн II,III шат I шаттай харьцуулахад алслагдмал Баруун болон Говийн бүсийн УТХГ-т хэрэгжиж байгаа тул ХШҮ-г хийхэд Улаанбаатараас явахад хол зайтай, зардал хугацаа их ордог тул орон нутгийн	Төслийн орон нутгийн ажилтан нар 2023 онд нийт 4 удаа томилолтоор ажилласнаас 1 удаа нийтийн тээврээр, 1 удаа гүйцэтгэгч байгууллагын машинаар, 1 удаа зөвлөх багийн машинаар, 1 удаа машин түрээсэлсэн бол 2024 онд 9 удаагийн томилолтыг бусдын автомашингаар гүйцэтгэсэн. Үүнд: 4 удаа зөвлөх багийн машинаар, 3 удаа нийтийн тээврээр, 1 удаа гүйцэтгэгч байгууллагын машинаар, 1 удаа хамгаалалатын захиргааны машинаар ажилласан байна.	8. БОАЖЯ, СЯ, KfW банк хооронд байгуулсан төслийн Тусгай гэрээний орон нутагт ажиллах орон тоог тохирсон заалт /Х.6-7/ 9. Төслийн ХШҮ-ний	 3. Bio 3 Separate agreement.pdf  БС чөлөөлөгдсөн тушаал20230904.pd

		ажилтан нар тогтмол газар дээр нь ажиллах шаардлагатай		төлөвлөгөөний хавсралтаар баталсан томилолтын төлөвлөгөөний биелэлт	 МЖ_20231123 6295.pdf  ХШҮ-ний 2024 оны томилолтын төлөвлөгөө
	Төслийн захиргааны ажилтны сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулаагүй. <i>Авах арга хэмжээ:</i> Захиргаа удирдлагын ажилтны батлагдсан ажлын даалгаврын дагуу шалгуур үзүүлэлтэд тэнцсэн, англи хэлний мэдлэгтэй хүнийг томилох	Оролцогч нарын дунд илүү чадвартай нэр дэвшигч нар байсан хэдий ч англи хэлний мэдлэггүй, төсөл хөтөлбөр дээр ажилласан туршлагагүй хүнийг сонгон шалгаруулж томилсон.	Үүнд: М.Санаажуу • Нийслэлийн бизнес инновац хөгжлийн газар /2022-2023/ • Нийслэлийн шинжлэх ухаан үйлдвэрлэл инновацын газар /2019-2022/ • Нийслэлийн үйлдвэрлэл инновацын газар /2018-2019/ • Монголын зочид буудлын холбоо ТББ /2016-2017/ • Завхан аймгийн БОАЖГ /2009-2015/ <i>Боловсрол:</i> Үйлдвэрийн экологийн инженер, ШУТИС /2004-2008/ Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн их сургууль, /2021-2022/	10. Төслийн захиргаа, удирдлагын ажилтны шалгуур үзүүлэлт, баталсан ажлын даалгавар 11. Захиргааны ажилтны намтар, холбогдох мэдээлэл 12. Оролцогч нарын бүртгэлийн хуудас, товч танилцуулга	 approved TOR_Admin2022.pdf  Announcement1_M ET2022.jpg
№	Зөрчил, авах арга хэмжээ	Тайлбар, тодруулга	Холбогдох бичиг баримт, мэдээлэл	Хавсралтын жагсаалт	Эх сурвалж
	ТХН-ийн ажилчдын цалинг буруу тогтоосон. <i>Авах арга хэмжээ:</i> Цалингийн тооцооллыг шалгах, Сангийн ямаар хянуулах, шинэчлэн тогтоох, илүү авч байсан мөнгийг улсад буцаан төлүүлэх, улсыг хохиролгүй болгох	• Захиргааны ажилтны үндсэн цалинг 4 саяар тооцсоноос гадна ямар ч төсөл дээр ажиллаагүй байхад 3 төсөл дээр ажилласан гэж 9%-ийн нэмэгдэл олгон төслийн захиргааны ажилтан 5 саяас дээш цалин авч байна. • Захиргаа удирдлагын ажилтан, Сургалт судалгаа хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан нарыг туршилтын хугацаагүй томилсон, шууд жинхэлсэн.	Сангийн сайдын 2024.01.23-ны өдрийн 13 дугаартай цалин тогтоох “Маягт шинэчлэх батлах тухай” тушаалыг зөрчсөн.	13. Сангийн сайдын 2024 оны 13 дугаартай “Маягт шинэчлэх батлах тухай” тушаал 14. БОАЖЯ-ны ТНБД-ын 2024 оны А/64 дугаартай “Цалин шинэчлэн тогтоох тухай” тушаал 15. Захиргааны ажилтны сонгон шалгаруулалтад ирүүлсэн материал	 2024.01.23 дугаар 13-Сангийн сайдын  20240229 цалин (1).pdf

	2023 оны 05 сард шинэ зохицуулагч томилогдсоноос хойш нэг жилийн хугацаанд төсөл хэрэгжүүлэх нэгжээс нийт 7 хүнийг ажлаас нь чөлөөлж, өөрчилж сольсон. <i>Авах арга хэмжээ:</i> • <i>ТХН-ийн бүтэц орон тооны тогтвортой байдлыг хангах;</i> • <i>Сонгон шалгаруулалтыг ил тод, шударга явуулах;</i> • <i>Сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн гишүүдийг солонгоруулах, зөвлөх багаас төлөөлөл оруулах;</i>	ТХН батлагдсан орон тоогоор ажилладаггүй, 2024 онд 2 удаа барилгын инженер, 2 удаа хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан томилсон.		16. Төслийн зохицуулагчийг халсан, томилсон тушаал 17. Захиргааны ажилтныг халсан, томилсон тушаал 18. Санхүүгийн ажилтныг халсан, томилсон тушаал 19. Худалдан авалтын ажилтныг халсан тушаал 20. Жолоочийг халсан, томилсон тушаал 21. Сургалт судалгаа, хэвлэл мэдээллийн ажилтныг томилсон, халсан болон дахин томилсон тушаал 22. Барилгын инженерийг томилсон, халсан болон дахин томилсон тушаал 23. Худалдан авалтын ажилтныг халсан тушаал БОННМ-ийн ажилтныг халсан болон томилсон тушаал	Төслийн сул орон тоог нөхөх ажлын :
	Төслийн хүрээнд олгосон бартаат замын машины хуваарилалтыг хэрэгцээ шаардлагын судалгаагүй, санхүүжүүлэгч байгууллагад урьдчилан	• Төслийн II, III шатанд хамааралгүй Төвийн бүсийн, төслийн хүрээнд 2022 онд Ландкрузер автомашин авч байсан Богдхан уулын ДЦГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн.	2019.06.26-ны өдөр БОАЖЯ, СЯ, KfW банк хооронд байгуулсан төслийн Тусгай гэрээний 4-т: Төслийн бүтцийг өөрчлөх: “Төслийн бүтцийн аливаа өөрчлөлтөд KfW-аас урьдчилан зөвшөөрөл авахыг шаарддаг бөгөөд үүнд худалдан авалт болон төлбөрийн журмын талаарх томоохон	24. Бартаат замын машины хуваарилалтыг шинэчилсэн тушаал 25. Бартаат замын машины хуучин	https://www.24tsag.mn/a/226311

	мэдэгдэлгүй өөрчилсөн, төслийн II, III шатанд хамааралгүй байгууллагад давхцуулан олгосон. <i>Авах арга хэмжээ: БОУАӨЯ-ны Өмч хамгаалах зөвлөл тус асуудлыг хянан шалгаж, давхацсан автомашинуудыг хэрэгцээ шаардлагатай газар нь шилжүүлэн хуваарилах</i>	- Төслийн II, III шатанд хамааралгүй Төвийн бүсийн, төслийн хүрээнд 2017 онд Ландкрузер автомашин авч байсан Горхи Тэрэлжийн БЦГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн. - Төслийн II, III шатанд хамааралгүй сонгуулийн 4-р тойрог болох Булган аймгийн БОАЖГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн. - Төслийн II, III шатанд хамааралгүй сонгуулийн 4-р тойрог болох Хөвсгөл аймгийн Тэс гол Булнайн нурууны БЦГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн. Төслийн II шатны хүрээнд 2022 онд машин авсан Мөнххайрханы БЦГ-т 2024 онд Ниссан Y61 өгсөн.	өөрчлөлтүүд орно. Төсөл хэрэгжүүлэх агентлаг нь өөрчлөлтийн тухай KfW-д цаг тухайд нь мэдэгдэж, түүний шалтгаан, төлөвлөсөн арга хэмжээ, үр дагаврыг (нийт зардлыг оролцуулан) мэдэгдэнэ. Ийм арга хэмжээ нь зөвхөн дахин хянагдсан төлөвлөгөө болоод KfW-ийн зөвшөөрөлд үндэслэн хэрэгжиж эхэлнэ.” гэсэн заалтыг зөрчсөн.	хуваарилалтын судалгаа, харьцуулалт 26. БОАЖ-ын сайдын 2024.03.14-ний өдрийн 01/1161 дугаартай албан захидал 27. ГСБЗБ-ны албан захидал	 Хавсралт 1_Бартаат замын машины хувь  Хавсралт 1-1_Бартаат замын  Approved MoM Plan2024.pdf
	Төслийн хүрээнд олгосон бартаат замын мотоциклийн хуваарилалтыг хэрэгцээ шаардлагын судалгаагүй, санхүүжүүлэгч байгууллагад урьдчилан мэдэгдэлгүй өөрчилсөн. <i>Авсан арга хэмжээ: Санхүүжүүлэгч байгууллагын удаа дараагийн шаардлагын дагуу шинэчилсэн тушаалыг хүчингүй болгож, хуучин хуваарилалтаар олгосон</i>	Төслийн хүрээнд олгох бартаат замын 200 ш мотоциклоос 75 ширхэг мотоциклийг Төслийн II, III шатанд хамааралгүй газар шинэчлэн хуваарилж, тараасныг санхүүжүүлэгч байгууллага удаа дараа шаардлага тавьсны дүнд шинэчилсэн тушаалыг хүчингүй болгож, хуучин хуваарилалтаар олгосон.	Төслийн хүрээнд нийлүүлж буй тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг гардуулах ёслолын ажиллагааг ЭСЯ болон санхүүжүүлэгч байгууллагад мэдэгдэлгүй зохион байгуулсан. Төслийн санхүүжүүлэгч байгууллага 2024 оны 10 дугаар сард Монгол Усад ажиллахдаа тухайн зөөврийн компьютерын байршил, эзнийг тодруулж, мэдэгдэх, зорилтот бүлгэд буцаан олгохыг даалгасан ч хэн авсан нь тодорхойгүй байгаа хэвээр байна. Дээрх тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг /Булган аймагт өгсөн машин, компьютерыг сонгуулийн лоббид ашигласан байх магадлалтай/	28. Бартаат замын мотоциклийн хуваарилалтыг шинэчилсэн тушаал 29. Бартаат замын мотоциклийн хуучин тушаал 30. БОАЖ-ын сайдын 2024.03.14-ний өдрийн 01/1161 дугаартай албан захидал 31. ГСБЗБ-ны 2024.02.06-ны өдрийн албан захидал	https://www.facebook.com/photo.php?fbid=615075537324795&id=100064670623110&set=a.247633647402321&local_e=zh_CN  Хавсралт 2_Бартаат замын мотоциклий  MoM2024 Mission (2).pdf

	Бартаат замын мотоциклийн ажлын даалгаврыг санхүүжүүлэгч байгууллагад урьдчилан мэдэгдэлгүй өөрчилсөн. <i>Авах арга хэмжээ:</i> <i>Судалгааг дахин гаргаж, хүч муутай мотоциклуудыг хээрийн бүсүүдэд шилжүүлэх</i>	Тендерийн үнэлгээний хороо нь ТХБ-ын ажлын хэсэг бөгөөд захиалагч тал бартаат замын мотоциклийн хүчин чадлыг 256 моторын хүчийг 125 болгож бууруулсан. Энэ өөрчлөлтийн мөрөөр ХШҮ хийхэд мотоциклийн чанар орон нутагт шаардлага хангахгүй хүнд нөхцөлтэй байна.		32. ХШҮ-ний 2024 оны 06 дугаар сард Зүүн бүсэд ажилласан ажлын тайлан 33. Тендерийн үнэлгээний явцын танилцуулга	 Зүүн бүсийн томилолт хаасан бг  Хавсралт 5_мотоцикл ТНБД-д
	Төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу ХЗ-дад олгоогүй <i>Авах арга хэмжээ:</i> <i>БОУАӨЯ хуваарийн дагуу хамгаалалтын захиргаадад хүргүүлэх</i>	MONNCB-04/23 дугаартай тендерээр 39 байгууллагад өгөх зөөврийн компьютерыг хуяаарилалт, ажлын даалгаврын дагуу тухайн байгууллагуудад өгөөгүй. Нийт 45 компьютер авснаас БОУАӨЯ 6 авах байсан ч 39-ийг нь одоог хүртэл ХЗ-дад хуваарилаагүй, энэ компьютерүүд хаана байгаа нь тодорхой биш байна.		34. ХШҮ-ний 2024 оны 06 дугаар сард Зүүн бүсэд ажилласан ажлын тайлан (Х.42) 35. Төслийн хүрээнд олгосон компьютерийн хуваарилалт	 Зүүн бүсийн томилолт хаасан бг  Хавсралт 3_PC хуваарилалт.pdf
	2023 оны Хөлсөөр ажиллах гэрээний үнэлгээг Сангийн яамны журмын дагуу үнэлээгүй, ажилтан нарт танилцуулалгүй, тэдгээрийн өөрсдийн үнэлгээг үл хэрэгсэн, саналыг нь авалгүй дүгнэсэн, халсан. <i>Авах арга хэмжээ:</i> <i>ТХН-ийн ажилтан нарын 2023 оны Хөлсөөр ажиллах гэрээний үнэлгээг нягтлах, Сангийн яамны Маягт 3-ын дагуу дахин үнэлэх</i>	Нийт 11 ажилтнаас 2 хүн F, 5 хүн D үнэлгээ тавьсан. Санхүүгийн ажилтан, ХАА ажилтан, ХШҮ ажилтан, БОННМА зэрэг нийт 4 ажилтан үнэлгээгээ зөвшөөрөхгүй байгаа тухай ажлын биелэлтээ шалгуулах хүсэлтээ гаргасан ч дахин үнэлгээг хийгээгүй, дээрх ажилтан нараас 4 нь ажлаас чөлөөлөгдсөн болно.	ТХН-ийн ажилтан нарын ажлын гүйцэтгэлийг энэхүү үнэлэхдээ Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журмын хавсралт “Маягт 3 Хөлсөөр ажиллах гэрээг үнэлэх хуудасны загвар”-ыг ашиглаагүй нь тус журмыг зөрчсөн болно.	36. Засгийн газрын 2016 оны 176 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын тусламж авах, зарцуулах, удирдах, бүртгэх, тайлагнах” журмын хавсралт “Маягт 3” 37. Ажилтан нарын ажлынхаа биелэлтийг шалгуулах тухай хүсэлтүүд 38. Төслийн 2023 оны үйл ажиллагааны	 БОУАӨЯ-нд гомдол - 2024.11.19.pdf

				хэрэгжилтийн тайлан;	
	УХХ-ын шийдвэрийн төслийг УХ-ны гишүүдэд танилцуулалгүй албажуулсан <i>Авах арга хэмжээ:</i> 2024 оны 03 сарын 01-ний өдөр хуралдсан удирдах хорооны хурлын тэмдэглэлийг гишүүдэд танилцуулах, албажуулах	ТХН-ийн ажилчдын ажиллах дотоод журмыг ажилчдаар хэлэлцүүлэлгүй, танилцуулалгүй баталсан.	УХХ-ын протоколд гишүүдийг гарын үсэг зуруулдаггүй, хурлаас гарах шийдвэрийг зөвхөн төслийн зохицуулагч, УХ-ны дарга нар боловсруулж, албажуулдаг тул баримт бичгийн эх хувь байхгүй	39. Удирдах хорооны шийдвэр, хурлын тэмдэглэлийн төсөл 40. Удирдах хорооны хурлын гарын үсэг дутуу шийдвэр	 ТУХ хурлын тэмдэглэл 2024.pdf
	ТХН-ийн батлагдсан дотоод журмыг дотоод журмыг ажилчдаар хэлэлцүүлэлгүй өөрчилсөн. <i>Авах арга хэмжээ:</i> АБТ-уудыг дахин нягтлах, шаардлагатай тохиолдолд шинэчлэн батлуулах	Ажлын байрны тодорхойлолтыг төслийн хэрэгцээ шаардлагад биш хүнд нь тохируулж өөрчилсөн.	2023-2024 оны тушаал шийдвэр, ирсэн явсан албан бичиг, шинээр баталсан журам, ажлын байрны тодорхойлолт зэрэг төслийн холбогдох баримт бичгүүд нууцмал байдалд байдаг учир төслийн баримт бичигт ХШҮ хийх боломжгүй болсон. Төслийн бичиг баримтыг өгөхгүй байгаа тул ХШҮ хийх боломжгүй байгаа тухай удирдлагад мэдэгдсэн цахим мэйлийг хавсаргав.	41. ТХН-ийн баталсан дотоод журам, АБТ 42. Шинэчилсэн дотоод журам, АБТ	 Дотоод журам.pdf
	Төслийн IT хариуцсан ажилтныг сольж, ажилчдад урьдчилан мэдэгдэлгүйгээр ажлын өрөөнд камер байршуулсан. <i>Авсан арга хэмжээ:</i> Санхүүжүүлэгч байгууллагын шаардлагаар камерыг буцаан авсан.			43. Төслийн зөвлөх багийн БОННМ-ийн зөвлөхийн тайлан	

	Төслийн хүрээнд зохион байгуулагдсан тендерийг шалгуулахдаа орчуулгыг ХАА-ны ажилтан нар өөрсдөө хийдэг <i>Авах арга хэмжээ:</i> <i>Тендерийн материалыг албан ёсны орчуулгын байгууллагаар хийлгэх</i>	2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.05-д: Төслийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн бичиг баримтын мэргэжлийн орчуулга хийлгэх ажлыг төлөвлөсөн ч ХАА-ны ажилтан нар ТББ-аа өөрсдөө орчуулж, санхүүжүүлэгч байгууллагад илгээсэн.	ХАА нарт маш их ачаалал болдог бол нөгөө талаас санхүүжүүлэгч байгууллага шаарддаг.	44. Оноолтоор шалгасан нийт 5 тендерийн жагсаалт	 Approved OP 2024_eng 20240301.
	Төслийн хэрэгжилтийн хоцрогдолтой байдал, төслийн хүрээний зөрчлийг илрүүлсэн, тулгамдсан асуудлыг, шийдвэрлэх зөвлөмж, саналын хамт төслийн удирдлагад тайлангаар мэдээлсэн,	Төслийн тулгамдсан асуудлыг дээд байгууллагад мэдээлсэн гэж ХШҮ-ний ажилтанд сахилгын шийтгэл өгсөн арга хэмжээ авсан.	Тус сахилгын шийтгэлийг болон Үр дүнгийн гэрээний үнэлгээг зөвшөөрөөгүйтэй холбогдуулан “Ажил үүргийн биелэлтээ шалгуулах хүсэлт” бүхий өргөдлийг 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр болон 11 дүгээр сарын 19-ний өдөр тус тус төслийн захиалагч тал болох БОУАӨЯ-нд гаргасан.	45. Төслийн 2023-2024 оны төлөвлөгөө, жилийн эцсийн тайлан 46. Хэрэгжилтийн үнэлгээний матриц	 Хавсралт 7 Approved MoM Plan  BACCP_Final_OPR2024_phaseII_2312202.
				47. Төслийн ХШҮ-ний томилолтын төлөвлөгөөний биелэлт 48. 2023 оны үнэлгээний тайлан 49. 2024 оны I болон III улирлын үнэлгээний тайлан 50. Сахилгын шийтгэл оногдуулсан хуудас	 БОУАӨЯ-нд гомдол - 2024.11.19.pdf

ДҮГНЭЛТ

Тус төсөл нь Санхүүгийн хамтын ажиллагааны төсөл учир техникийн хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөртэй харьцуулахад бодит хөрөнгө оруулалт хийдээг бөгөөд төслийн хувьд худалдан авах ажиллагаа, түүний бэлтгэл ажил болох хэрэгцээ шаардлагын судалгаа хийх, техникийн тодорхойлолт, тендерийн бичиг баримт, ажлын даалгаврыг боловсруулах болон ХАА-ны үр дүнд байгуулагдах ажил, бараа, зөвлөх үйлчилгээ нийлүүлэх ажлын гэрээ, тэдгээрийн хэрэгжилт зэрэг төслийн үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэнэ.

Төслийн санхүүжүүлэгч байгууллага болох Германы Сэргээн босголт, зээлийн (KfW) банкны 2024 оны үнэлгээний багаас төслийн стратегийн чиг баримжаа дутмаг байгаагаас цогцоор нь өөрчлөхөөс гадна тогтвортой үр дүн, нөлөөллийн талаар тодорхой анхаарал хандуулдаггүй богино хугацааны арга хэмжээ, түр зуурын хэрэгцээнд ихээхэн анхаарал хандуулж байгааг онцлон тэмдэглэсэн. Хөрөнгө оруулалтыг төлөвлөгөөг боловсруулахдаа ТХГН-уудын менежмент төлөвлөгөөтэй уялдуулан, ТХГН-ийн хэрэгцээ шаардлага дээр үндэслэсэн байх шаардлагатай.

Төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлаас илүү үр дүнг гаргах, төсөл дууссанаас хойш тогтвортой, урт хугацааны хөрөнгө оруулалт болгож үлдээх нь хугацаа, зарцуулалтын хэмжээнээс илүү чухал гэж үзэж байна. Иймд УАТ нь төслийн хэрэгжилтийн үр ашгийг баталгаажуулахын тулд жижиг хэмжээний худалдан авалтаас илүүтэй томоохон, чухал үйл ажиллагаа руу төвлөрөх нь зүйтэй.

Төслийн хүрээнд үйл ажиллагааг ил тод байлгаж, төслийн зөвлөх баг болон бусад холбогдох талуудыг оролцуулах, шийдвэрийг хамтран гаргах, ТХН, ЗБ-ийн хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах байнгын бөгөөд олон талт харилцаатай байх, мөн KfW Банкад урьдчилан мэдэгдсэн байх ёстойг санхүүжүүлэгч тал анхааруулсан болно.

2024 онд төслийн нэгжийн үйл ажиллагаанд нөлөөлөх дараах хүчин зүйлс гарсан. Үүнд: Төслийн удирдлагууд удаа дараа солигдож, төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтнууд шинэчлэгдсэн Мөн 2024 Сонгуулийн жил, ОХУ-Украины дайн, дэлхий нийтэд үүсээд буй эдийн засгийн хүнд байдал, төгрөгийн ханшийн тогтворгүй байдал, инфляцын нөлөө нь тендерүүдийн үнийн дүн нөлөөлж, гэрээнүүд сунгагдаж, гүйцэтгэл хойшилсон.

Төслийн 2024 оны үйл ажиллагааны хэрэгжилт 64,8 хувьтай олон ажил хоцрогдож он дамжиж хийгдэхээр хойшилсон, ялангуяа барилгын байшингийн загвар төслийн болон орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь төслийн 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлд томоохон сөрөг үзүүлэлт болсон.

БОЛОВСРУУЛСАН:
ТӨСЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН АЖИЛТАН



Ц.ЭНХСАЙХАН

2025 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр